

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА,  
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 33 А/22 А/101

Улаанбаатар хот

Журам батлах тухай



Монгол Улсын Их хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 3.12, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төрийн өндөр албан тушаалтан, тэдгээрийн зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтан, гадаад улсын төр, засгийн өндөр, дээд хэмжээний зочин, төлөөлөгч, Монгол Улсаас гадаад улсад суугаа болон гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, Засгийн газар хоорондын Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгч нар болон эрх бүхий бусад үйлчлүүлэгчдийг гадаад улсад явах болон ирэх үед Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндий дэх “Чингис Хаан” Олон улсын нисэх буудалд угтах, үдэх ажлыг зохион байгуулах, хариуцан гүйцэтгэх албаны хүмүүст “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Чингис Хаан” Олон улсын нисэх буудлын “Төрийн хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам”-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг Олон улсын нисэх буудлын үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс мөрдлөг болгон ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар, Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын газар болон “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Чингис Хаан” Олон улсын нисэх буудлын “Төрийн хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам батлах тухай” Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад харилцааны сайд болон Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд нарын хамтарсан 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 89/А/34/103 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад харилцааны сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2020 оны 25 дүгээр сарын 21-ны өдрийн 33/24 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт

## “ЧИНГИС ХААН” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ТӨРИЙН ХҮНДЭТ ЗОЧНЫ ТАНХИМААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ ЖУРАМ

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын төрийн өндөр албан тушаалтан, тэдгээрийн зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтан, гадаадын төр, засгийн өндөр, дээд хэмжээний зочин, төлөөлөгч, Монгол Улсаас гадаад улсад суугаа болон гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, Засгийн газар хоорондын Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгч нар болон эрх бүхий бусад үйлчлүүлэгчдийг гадаад улсад явах болон ирэх үед Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндий дэх “Чингис Хаан” Олон улсын нисэх буудалд угтах, үдэх ажлыг зохион байгуулах, хариуцан гүйцэтгэх албаны хүмүүст “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Монгол Улсын төрийн өндөр албан тушаалтан, тэдгээрийн зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтан, гадаад улсын төр, засгийн дээд, өндөр хэмжээний төлөөлөгчдийн “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх захиалгыг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар (цаашид “Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар” гэх), гадаад улсын өндөр, дээд түвшний албан тушаалтнууд болон адилтгах албан тушаалтан, зочид, төлөөлөгчид, Монгол Улсаас гадаад улсад суугаа болон гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, Засгийн газар хоорондын Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгчийн газруудын захиалгыг Гадаад харилцааны яамны Дипломат ёслолын газар (цаашид “Дипломат ёслолын газар” гэх) тус тус хүлээн авч “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн Хүндэт зочны үйлчилгээний албанд нислэгээс 24 цагийн өмнө хүргүүлж баталгаажуулна.

1.3. Энэхүү журмын хоёр, гурав, дөрөвдүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу олгогдсон зөвшөөрлийн хуудас /цаашид “Зөвшөөрлийн хуудас” гэх/-аар болон Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар, Дипломат ёслолын газраар баталгаажсан и-мэйл, факсаар өгөгдсөн захиалгыг албан ёсны гэж үзнэ.

1.4. “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх захиалгыг хүлээн авсан тухайгаа “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК нь Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар, Дипломат ёслолын газарт и-мэйл, утсаар болон факсаар эргэн мэдэгдэх бөгөөд “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэгчдийн явсан, ирсэн талаар бүртгэл хөтөлнө.

1.5. Захиалгыг хүлээн авсан Хүндэт зочны үйлчилгээний алба нь мэдээллийг агаарын тээвэрлэгч болон хилийн хяналтын байгууллагуудын томилогдсон ажилтанд шуурхай мэдэгдэнэ.

1.6. “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх зөвшөөрлийн хуудсыг бусдад дамжуулах, үйлчлүүлэгчийн овог, нэр, аяллын чиглэлийг өөрчлөх, засварлахыг хориглоно.

1.7. Нийтээр тэмдэглэх баяр болон амралтын өдрүүдэд “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх захиалга өгөх тохиолдолд Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар, Дипломат ёслолын газрын захиалгыг “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн Хүндэт зочны үйлчилгээний албанд и-мэйл, утсаар өгч дараа нь зөвшөөрлийн хуудсаар баталгаажуулна.

1.8. “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх эрх бүхий албан тушаалтны захиалга, зөвшөөрлийн хуудас, үнэмлэх болон бусад холбогдох баримт бичгийг шалгаж нэвтрүүлэх асуудлыг Иргэний нисэхийн дүрэм /ИНД-140/-ээр гэрчилгээжсэн Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага гэрээний үндсэн дээр хариуцан гүйцэтгэнэ.

1.9. “Төрийн хүндэт зочны танхим”-аар журмын 2.1.1-т заасан албан тушаалтнууд үнэ төлбөргүй үйлчлүүлнэ.

1.10. Журмын 2.1.2-т заасан албан тушаалтнууд, журмын 2.1 дэх заалтад тусгагдаагүй бусад үйлчлүүлэгчдийн “Төрийн хүндэт зочны танхим”-ын үйлчилгээний цар хүрээ, төлбөрийн хэмжээг “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК нь Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар, Дипломат ёслолын газартай зөвшилцөн тогтооно.

1.11. Төлбөрийг “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх тухай бүр төлнө.

1.12. Энэхүү журмын хэрэгжилтэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам хяналт тавьж, хамтран тохиролцсоны дагуу нэмэлт, өөрчлөлт тодотгол хийж болно.

#### Хоёр. “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх эрх бүхий албан тушаалтнууд

2.1. “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх төрийн өндөр албан тушаалтан, тэдгээрийн зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтан, гадаад улсын өндөр, дээд хэмжээний зочин, төлөөлөгч, дипломат байгууллагын тэргүүн, албан тушаалтнууд.

2.1.1. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 19 дүгээр тогтоолын хавсралтад дурдсан дараах албан тушаалтнууд үнэ төлбөргүй үйлчлүүлнэ. Үүнд:

- а) Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний гэр бүл;
- б) УИХ-ын дарга, түүний гэр бүл;
- в) Монгол Улсын Ерөнхий сайд, түүний гэр бүл;
- г) УИХ-ын дэд дарга, Шадар сайд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч;
- д) УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Ерөнхий прокурор;

- е) Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, ЗГХЭГ-ын дарга, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Дээд шүүхийн шүүгч;
- ё) Монгол Улсын Их Хурлын “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” 2019 оны 19 дүгээр тогтоолын ТӨ-I-т хамаарах албан тушаал хашиж байсан албан тушаалтан, тэдгээрийн гэр бүл хугацаагүй, харин ТӨ-II-т хамаарах албан тушаал хашиж байсан албан тушаалтан, тэдгээрийн гэр бүлийг Төрийн тусгай хамгаалалтад байх хугацаанд;
- ж) Гадаад улсын төр, засгийн тэргүүн, түүний гэр бүл;
- з) Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдын албан ёсны айлчлалын ажлын болон хамгаалалт, үйлчилгээ, хэвлэл мэдээллийн хэсгийн Дипломат ёслолын газраас олгосон “Зөвшөөрлийн хуудас”-аар төлбөрөөс чөлөөлөгдсөн бүрэлдэхүүн 10 хүртэл хүн;
- л) Гадаад улсын өндөр, дээд түвшний айлчлалын үеэр “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх Дипломат ёслолын газраас олгосон “Зөвшөөрлийн хуудас”-аар төлбөрөөс чөлөөлөгдсөн албан тушаалтан 10 хүртэл хүн;
- м) Гадаад улсаас Монгол Улсад суух Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, түүний гэр бүл, Засгийн газар хоорондын Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгч нарыг Монгол Улсад анх удаа ирэх болон бүрмөсөн буцахад;
- н) Монгол Улсаас гадаад улсад суух Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, түүний гэр бүл нарыг томилогдон явах болон бүрмөсөн буцан ирэхэд;

2.1.2. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 19 дүгээр тогтоолын хавсралтад дурдсан дараах албан тушаалтнууд хөнгөлөлттэй төлбөрөөр үйлчлүүлнэ. Үүнд:

- а) Дэд сайд, ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга;
- б) Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч;
- в) Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий аудитор, Авилгатай тэмцэх газрын дарга;
- г) Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Аймгийн Засаг дарга;
- д) Төрийн албаны зөвлөлийн дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Ерөнхий прокурорын орлогч, Хүний

эрхийн үндэсний комиссын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Авилгатай тэмцэх газрын дэд дарга;

- е) Ерөнхийлөгчийн зөвлөх, УИХ-ын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх; Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн
- ё) Монголбанкны Тэргүүн дэд, дэд Ерөнхийлөгч, Ерөнхий аудиторын орлогч, Үндэсний статистикийн хорооны дэд дарга, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга;
- ж) Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн;
- з) Яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- л) Засгийн газрын агентлагийн дарга;
- м) Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар, Дипломат ёслолын газраас хүндэтгэл үзүүлэх шаардлагатай гэж үзсэн олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын удирдлага;
- н) Журмын 2.1.1-ийн г,д,е хэсэг ба 2.1.2 дахь заалтуудад заасан албан тушаалтнуудын гэр бүл.

2.2. Монгол Улсын төрийн өндөр албан тушаалтан, тэдгээртэй адилтгах зэрэг зиндааны гадаадын зочин, төлөөлөгчдийг “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх үед дагалдах тусгай хамгаалалтын болон үйлчилгээний ажилтны нэрс, нийт тоог Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар, Дипломат ёслолын газар хариуцан “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн Хүндэт зочны үйлчилгээний албанд хүргүүлнэ.

2.3. Журмын 2.1.1-ийн а,б,в,ё,ж,м,н хэсэг ба 2.1.2 дахь хэсгийн (н) заалтын “гэр бүл” гэснийг зөвхөн тухайн хүний эхнэр, нөхөр, насанд хүрээгүй хүүхэд гэж ойлгоно.

2.4. Энэ журмын 2.1 дэх заалтад дурдагдаагүй зорчигч, үйлчлүүлэгчдэд “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн “Төрийн хүндэт зочны танхим”-ын үйл ажиллагааны дотоод заавар, журмын дагуу төлбөртэй үйлчилгээ үзүүлнэ.

#### Гурав. “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх

3.1. Энэхүү журмын 2 дугаар хэсэгт дурдсан албан тушаалтнууд, тэднийг угтаж, үдэж байгаа хүмүүс Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар, Дипломат ёслолын газар, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-иас олгосон “Зөвшөөрлийн хуудас”-ыг гадаад паспорт, иргэний үнэмлэхийн хамт Иргэний нисэхийн дүрэм /ИНД-140/-ээр гэрчилгээжсэн Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын ажилтанд шалгуулж нэвтэрнэ.

3.2. “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлж байгаа албан тушаалтан, гадаад улсын зочин төлөөлөгчид хил нэвтрэх бичиг баримтыг хил хамгаалах байгууллагын ажилтанд шалгуулна.

3.3. “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлж байгаа албан тушаалтан, гадаад улсын зочин, төлөөлөгчид гар тээш, тээшээ холбогдох хууль тогтоомжийн дагуу аюулгүй байдлын болон хилийн хяналт шалгалтын үзлэгт хамруулах үүрэгтэй.

3.4. Төрийн тусгай хамгаалалтад байгаа албан тушаалтан, иргэнийг гаалийн болон аюулгүй байдлын үзлэгээс чөлөөлнө.

3.5. Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон Засгийн газар хоорондын Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгчдийн газруудад олгодог “Чингис хаан” ОУНБ-ын нэвтрэх үнэмлэх нь “Төрийн хүндэт зочны танхим”-д нэвтрэхэд ашиглагдахгүй.

3.6. Дипломат эрх бүхий ажилтан аюулгүй байдлын үзлэгт хамрагдана. Дипломат эрх бүхий ажилтны гар тээш, тээшинд үзлэг хийхдээ дипломат харилцааны тухай Венийн конвенцийн (1961) холбогдох заалтын дагуу өөрийг нь, эсхүл түүнийг төлөөлөх бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулна.


3.7. Зохих журмын дагуу лацадсан дипломат шуудангийн илгээмжид гаалийн болон аюулгүй байдлын үзлэг хийхгүй.

3.8. “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэх зорчигчийн тийз, тээш бүртгэл, хил, гааль, мэргэжлийн хяналтын үзлэгийг агаарын хөлөг хөөрөхөөс 30 минутын өмнө дуусгасан байна.

3.9. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Гадаад улсын төр, засгийн болон олон улсын байгууллагын тэргүүнийг нисэх буудалд угтан авах, үдэн гаргах үйл ажиллагааг “Монгол Улсын Төрийн ёслолын журам”-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

3.10. “Төрийн хүндэт зочны танхим”-аар үйлчлүүлэгчдийг угтан авах, үдэн гаргах ажлыг зөвхөн энэ танхимд гүйцэтгэнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдыг угтах, үдэх болон тэдгээртэй адилтгах зиндааны гадаад улсын зочин, төлөөлөгчдийг угтах, үдэх ажлыг Төрийн ёслол, хамтын ажиллагааны газар болон Дипломат ёслолын газар зохион байгуулна. Бусад албан тушаалтан, зочин, төлөөлөгчдийг Хүндэт зочны үйлчилгээний албаны ажилтан агаарын хөлгийн хоолой дээрээс угтах, үдэх, чиглүүлэх ажлыг зохион байгуулна.

3.11. Энэхүү журмын хэрэгжилтийг хангах “Чингис Хаан” Олон улсын нисэх буудлын “Төрийн хүндэт зочны танхим” нь үйл ажиллагааны дотоод заавар, журамтай байна.



Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад харилцааны сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2020 оны 05 дүгээр сарын 21-ны өдрийн 33/124 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ  
ДИПЛОМАТ ЁСЛОЛЫН ГАЗАР**

1118268063 5919487 СБТ9513

**Зөвшөөрлийн хуудас /Явах/**

№

20 ... оны ... сарын ...

Улаанбаатар хот  
Утас: 260713, 260093, Факс: 262225  
И-мэйл: protocol@cabinet.gov.mn

..... шугамаар 20 ... оны ...  
сарын...-ны (ний) өдрөөс ... сарын ... -ны (ний) өдөр ..... чиглэлийн  
...../.....-ны (ний) дугаар нислэгээр явах .....  
тэргүүтэй .....

нарын ..... хүнийг “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын “ТӨРИЙН ХҮНДЭТ  
ЗОЧНЫ ТАНХИМ”-аар үйлчлүүлэхийг зөвшөөрөв.  
Үдэн мордуулах .....

..... нар, нийт ..... хүн болно.

Машины улсын дугаар: .....  
Хилийн боомтын бүсэд (хоолойд) ..... нэвтэрнэ.

ДАРГА

/...../



**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ  
ДИПЛОМАТ ЁСЛОЛЫН ГАЗАР**

**Зөвшөөрлийн хуудас /Ирэх/**

№

20 ... оны ... сарын ...

Улаанбаатар хот  
Утас: 260713, 260093, Факс: 262225  
И-мэйл: protocol@cabinet.gov.mn

..... шугамаар 20 ... оны ...  
сарын...-ны (ний) өдрөөс ... сарын ... -ны (ний) өдөр ..... чиглэлийн  
...../.....-ны (ний) дугаар нислэгээр ирэх .....  
тэргүүтэй .....

нарын ..... хүнийг “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын “ТӨРИЙН ХҮНДЭТ  
ЗОЧНЫ ТАНХИМ”-аар үйлчлүүлэхийг зөвшөөрөв.  
Угтан авах .....

..... нар, нийт ..... хүн болно.



Машины улсын дугаар: .....  
Хилийн боомтын бүсэд (хоолойд) ..... нэвтэрнэ.

ДАРГА

/...../



Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад харилцааны сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2020 оны 02 дүгээр сарын 21 -ны өдрийн ... дугаар тушаалын Гуравдугаар хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЁСЛОЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Зөвшөөрлийн хуудас /Явах/

№

20 ... оны ... сарын ...

Улаанбаатар хот  
Утас: 260713, 260093, Факс: 262225  
И-мэйл: protocol@cabinet.gov.mn

..... шугамаар 20 ... оны ...  
сарын...-ны (ний) өдрөөс ... сарын ... -ны (ний) өдөр ..... чиглэлийн  
...../.....-ны (ний) дугаар нислэгээр явах .....  
тэргүүтэй .....

нарын ..... хүнийг “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын “ТӨРИЙН ХҮНДЭТ  
ЗОЧНЫ ТАНХИМ”-аар үйлчлүүлэхийг зөвшөөрөв.

Үдэн мордуулах .....

..... нар, нийт .....хүн болно.

Машины улсын дугаар: .....  
Хилийн боомтын бүсэд (хоолойд) ..... нэвтэрнэ.

ДАРГА

/..... /



**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЁСЛОЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Зөвшөөрлийн хуудас /Ирэх/

№

20 ... оны ... сарын ...

Улаанбаатар хот  
Утас: 260713, 260093, Факс: 262225  
И-мэйл: protocol@cabinet.gov.mn

..... шугамаар 20 ... оны ...  
сарын...-ны (ний) өдрөөс ... сарын ... -ны (ний) өдөр ..... чиглэлийн  
...../.....-ны (ний) дугаар нислэгээр ирэх .....  
тэргүүтэй .....

нарын ..... хүнийг “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын “ТӨРИЙН ХҮНДЭТ  
ЗОЧНЫ ТАНХИМ”-аар үйлчлүүлэхийг зөвшөөрөв.

Угтан авах .....

..... нар, нийт .....хүн болно.

Машины улсын дугаар: .....  
Хилийн боомтын бүсэд (хоолойд) ..... нэвтэрнэ.

ДАРГА

/..... /



Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх-газрын дарга, Гадаад харилцааны сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2020 оны 05 дүгээр сарын 21-ны өдрийн 23/АБ/ дугаар тушаалын Дөрөвдүгээр хавсралт



**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК**

УХА0064

Зөвшөөрлийн хуудас /Явах/

№

20 ... оны ... сарын ...

Улаанбаатар хот  
Утас: 260713, 260093, Факс: 262225  
И-мэйл: protocol@cabinet.gov.mn

..... шугамаар 20 ... оны ...  
сарын...-ны (ний) өдрөөс ... сарын ... -ны (ний) өдөр ..... чиглэлийн  
...../.....-ны (ний) дугаар нислэгээр явах .....  
тэргүүтэй .....

нарын ..... хүнийг “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын “ТӨРИЙН ХҮНДЭТ  
ЗОЧНЫ ТАНХИМ”-аар үйлчлүүлэхийг зөвшөөрөв.

Үдэн мордуулах .....

..... нар, нийт .....хүн болно.

Машины улсын дугаар: .....  
Хилийн боомтын бүсэд (хоолойд) ..... нэвтэрнэ.

ЗАХИРАЛ

/...../



**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК**

Зөвшөөрлийн хуудас /Ирэх/

№

20 ... оны ... сарын ...

Улаанбаатар хот  
Утас: 260713, 260093, Факс: 262225  
И-мэйл: protocol@cabinet.gov.mn

..... шугамаар 20 ... оны ...  
сарын...-ны (ний) өдрөөс ... сарын ... -ны (ний) өдөр ..... чиглэлийн  
...../.....-ны (ний) дугаар нислэгээр ирэх .....  
тэргүүтэй .....

нарын ..... хүнийг “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын “ТӨРИЙН ХҮНДЭТ  
ЗОЧНЫ ТАНХИМ”-аар үйлчлүүлэхийг зөвшөөрөв.

Угтан авах .....

..... нар, нийт .....хүн болно.

Машины улсын дугаар: .....  
Хилийн боомтын бүсэд (хоолойд) ..... нэвтэрнэ.

ЗАХИРАЛ

/...../